

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 12 дугаар сарын 04-ний өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-6
1. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	4-5
2. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	5-6

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
12 дугаар сарын 04-ний өдөр /Пүрэв гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Бейсен ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 30 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 53.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 27 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: П.Батчимэг, Г.Ганбаатар, С.Ганбаатар, С.Лүндэг, Ц.Мөнхбат, Л.Мөнхбаясгалан, Р.Сэддорж, Ц.Туваан, А.Ундраа;
Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, С.Амарсайхан, Х.Ганхуяг.

Нэг. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Бадралт, Ц.Рэнцэнтогтох, Б.Энхгэрэл нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Б.Бейсен танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Бейсен: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	12
Татгалзсан:	5
Бүгд:	17

70.6 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 10 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Бадралт, Ц.Рэнцэнтогтох, Б.Энхгэрэл нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Б.Бейсен танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Бейсен: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 5

Бүгд: 17

70.6 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 06 минут үргэлжилж, 30 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр 10 цаг 33 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,

ХӨДӨӨ АЖ АХУЙН

БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ

ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 12 дугаар сарын 04-ны өдөр, Пүрэв гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим
10 цаг 27 минут.

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Б.Бейсен: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц 53,3 хувьтай бүрдсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 12 дугаар сарын 4-ний өдөр хуралдаан нээснийг мэдэгдье. Ирцийг танилцуулъя.

Наранцэцэгийн Алтаншагай ирсэн байна. Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн ирсэн байна. Жаргалсайханы Золжаргал гишүүн ирсэн байна. Тогтмолын Мөнхсайхан гишүүн ирсэн байна. Салдангийн Одонтуяа гишүүн ирсэн байна. Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн ирсэн байна. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн ирсэн байна. Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн ирсэн байна. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн ирсэн байна. Баатаржавын Мөнхсоёл гишүүн ирсэн байна. Ухнаагийн Отгонбаяр гишүүн ирсэн байна. Буланы Бейсен гишүүн ирсэн байна. Сонгабайн Замира гишүүн ирсэн байна. Мэндбаярыны Мандхай гишүүн ирсэн байна. Нанзадын Наранбаатар гишүүн ирсэн байна. Болдын Уянга гишүүн ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хэлэлцэх асуудал 1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

2 дахь асуудал. Байнгын хорооны тогтоолын төсөл /Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүд байна уу. Саналтай гишүүд байхгүй байна. Хыэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүд байхгүй учраас хэлэлцэх асуудалд оръё.

Тогтоолын төслийг танилцуулъя. Ажлын хэсэг байгуулах тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь заалт, хэсгийг үндэслэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос тогтоох нь:

1.Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсэг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагчаар Ж.Бат-Эрдэнэ Монгол Улсын Их Хурлын гишүүн,

Гишүүд Сонгобайн Замира Монгол Улсын Их Хурлын гишүүн, Нанзадын Наранбаатар Монгол Улсын Их Хурлын гишүүн, С.Лүндэг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Р.Сэддорж Монгол Улсын Их Хурлын гишүүн, Д.Жаргалсайхан Монгол Улсын Их Хурлын гишүүн.

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдлэг мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын албан тушаалтанд тухай бүрд нь татан оролцуулахыг ажлын хэсэг /Ж.Бат-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй гэсэн тогтоолын төсөл байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд байна уу. Асуулт, саналтай гишүүд байхгүй байна. Гишүүд санал хураалтад бэлдээрэй. Мөнхсоёл гишүүн та орж хараарай та ирцдээ орсныг нь өгчих. Санал хураалт. Ажлын хэсэг байгуулах тогтоолын төсөл 70,6 хувиар батлагдлаа. Ганхүлэг гишүүнийг дэмжсэнээр аваарай.

10.31 цаг.

Дараагийн асуудалд оръё.

Байнгын хорооны тогтоолын төсөл.

Байнгын хорооны тогтоолын төсөл танилцуулъя. Ажлын хэсэг байгуулах тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийг үндэслэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос тогтоох нь:

1.Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагчаар Тогтоомны Мөнхсайхан Монгол Улсын Их Хурлын гишүүн.

Гишүүдэд П.Батчимэг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Г.Ганбаатар Монгол Улсын Их Хурлын гишүүн, Н.Наранбаатар Монгол Улсын Их Хурлын гишүүн, А.Ундраа Монгол Улсын Их Хурлын гишүүн, Б.Уянга Монгол Улсын Их Хурлын гишүүн.

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын албан тушаалтныг тухай бүр татан оролцуулахыг ажлын хэсэг /Т.Мөнхсайхан/-д зөвшөөрсүгэй.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд байна уу. Асуулт, саналтай гишүүд байхгүй байна. Гишүүд санал хураалтад бэлдээрэй.

Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэдгээр санал хураалт явуулъя. Санал хураалт. Тогтоол 70,6 хувьтай батлагдлаа.

Байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Байнгын хорооны гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

10.33 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ